



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 8/25

Улаанбаатар хот


Г Т  
Бодлогын чиглэл батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, тус газрын Даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл”-ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Засгийн газрын тогтоол гараахтай холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллах, холбогдох төрийн, төрийн өмчийн болоод олон нийтийн байгууллагуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Б. Билэгдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЧИНБАТ



0000381

Болс-хүүлсан: С. Батчимэг  
Нийлсэн:  
Хүн:  
2019 онд сарын одор



ХХМТГ-ын даргын 2019 оны 22 сарын 02-ний өдрийн  
22 тоот тушаалын хавсралт



## ЗАСГИЙ ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

## ТӨРӨӨС НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЧИГЛЭЛ

2019 он

## Улаанбаатар хот

## АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ .....	3
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ .....	8
ХОЁР. УДИРТГАЛ .....	9
ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН ХЭРЭГЛЭЭ .....	11
ДӨРӨВ. БОДЛОГЫН ЧИГЛЭЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГУУД .....	12
4.1.    Нээлттэй өгөгдлийн удирдлага .....	12
4.2.    Нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах .....	13
4.3.    Нээлттэй өгөгдлийг цахим орчинд нийтлэх .....	13
4.4.    Нээлттэй өгөгдлийн форматууд .....	14
4.5.    Олон нийтийн хандлагыг тандах .....	15
4.6.    Тогтсон хуваарь, шийдлийн дагуу нийтлэх мэдээлэл .....	16
4.7.    Нэмэлт шаардлагууд .....	17
4.8.    Хэрэгжүүлэх арга замууд болон хэрэгжилтийг хянан нягтлах .....	17
Хавсралт 1. Нээлттэй өгөгдөл .....	19
Хавсралт 2. Гүйцэтгэх үүрэг болон хүлээх хариуцлага .....	23
Хавсралт 3. 2013 онд Их 8 улсын Нээлттэй өгөгдлийн талаарх зөвлөмж бүлэгт дурдсан зайлигүй ил тод болгох шаардлагатай нээлттэй өгөгдлийн категори .....	25
Хавсралт 4. Өгөгдлийн форматууд .....	27
Хавсралт 5. Эшлэл .....	30

## НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Өгөгдөл	Бүх төрлийн бүтэц бүрэлдэхүүнтэй мэдээллийг
Бүрдэл өгөгдөл	Тодорхой бүтэцтэй болон бүтэцгүй мөн ангилал хийгдэж болохуйц өгөгдөл
Үл тодорхойлох өгөгдөл	Тодорхой нэгэн хувь хүнийг илэрхийлэх өгөгдлөөс хувь хүнийг тодорхойлох, танихад хэрэглэгдэх өгөгдлүүдийг тусгаарласнаар тухайн этгээдийг танин тодорхойлох бололцоогүй болгосон өгөгдөл
Төрийн өгөгдөл	Төрийн байгууллагын цуглуулсан, үүсгэн бий болгосон болон хянан шинжилсэн өгөгдөл
Мета өгөгдөл	Хэсэгчилсэн өгөгдөл болон бүлэг өгөгдлийн нэг болоод түүнээс дээш тооны хэв шинжийг агуулсан мэдээлэл
Нээлттэй өгөгдөл	Нээлттэй, чөлөөтэй хандах бололцоотой дахин ашиглагдах болоод түгээн дамжуулж болохуйц аливаа хувийн мэдээлэл агуулаагүй өгөгдөл болон мэдээлэл түүнчлэн машинд уншигдахуйц форматтай байхаас гадна үнэ төлбөргүй байна
Хүсэлт гаргагч	Нээлттэй өгөгдлийн сан дахь бүлэг өгөгдлүүдэд хандалт хийж буй хувь хүн, аж ахуйн нэгжийг
Зохиогчийн эрх	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулинд тодорхойлсон утга. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль {2006.01.19}.
Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл	Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжил, цахим засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлагын түвшинд дэмжлэг үзүүлэх, манлайлах үүрэг бүхий Засгийн газрын харьяа байгууллагуудын удирдлагын түвшинд байгууллагдсан байнгын

	ажиллагаатай зөвлөл.
Мэдээлэл хүсэх	Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа иргэн, байнгын оршин суугч, хэсэг бүлэг болоод аж ахуйн нэгжийн зүгээс нээлттэй өгөгдлийн хүрээнд хэсэг өгөгдөл болон бүлэг өгөгдөл авахаар гаргасан хүсэлт
ХХМТГ	Засгийн газрын тохируулагч агентлаг <b>Харилцаа Холбоо</b> , Мэдээллийн Технологийн Газар
Машинд уншигдах, боловсруулагдах	Тодорхой бүтэц, тогтоцтой өгөгдөл нь компьютерийн програмын тусламжтайгаар автомат болон бусад аргаар үйлдэл хийгдэх боломжтой байна
Нээлттэй өгөгдлийн үнэлгээ	Тус бодлогын баримт бичгийн Хавсралт 3-т заасны дагуу хийгдэх үнэлгээ
Нээлттэй өгөгдлийн каталоги	Стандарт форматын дагуу өгөгдлийн тодорхойлолтыг агуулсан жагсаалт
Нээлттэй өгөгдлийн албан хаагч	Нээлттэй өгөгдлийн менежмент болон хэрэгжүүлэлтийг хангах үйл ажиллагааны хүрээнд зохих шатны байгууллагын Мэдээллийн технологийн хэлтэс, газар, нэгжийн зүгээс томилсон мэдээллийн технологийн албан хаагч
Нээлттэй зөвшөөрөл	Өгөгдөл, мэдээлэл нь нийтийн домайн болон өөр бусад домайн дээр байрласан эсэхээс үл хамааран нээлттэй зөвшөөрөл ашиглаж буй хэмээн тэмдэглэгдсэн тохиолдолд тухайн өгөгдөл нь нээлттэй хэмээн тооцогдох бөгөөд арилжааны болоод арилжааны бус зорилгоор ашиглах болон дахин хэрэглэхэд аливаа нэгэн хориг саад үгүй
Хувийн мэдээлэл:	А – Хувь хүнийг шууд тодорхойлох болоод тодорхойлж

чадахуйц түүнчлэн хувь хүнийг тодорхойлохуйц буюу  
бусад мэдээлэлтэй хоршсоноор хувь хүнийг тодорхойлж  
болох бүх төрлийн мэдээлэл;

Б – Тухайлан хэн нэгэн хувь хүнийг тодорхойлж болохуйц  
газар зүйн байршил агуулсан мэдээлэл түүнчлэн газар  
зүйн байршлын онцлогийг агуулсан мэдээлэл нь бусад  
мэдээлэлтэй хоршсоноор хувь хүнийг тодорхойлж  
 болохуйц бол;

В – Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын  
зүгээс албан ёсоор хувийн мэдээллийн ангилалд  
оруулсан мэдээлэл.

Статистикийн тухай хуулийн (шинэчилсэн найруулга 1997) 3 дугаар бүлэгт  
заасны дагуу хувь хүн нь өөрт хамаарах мэдээлэл нь статистикийн болоод бусад  
зорилгоор хэрэглэгдэж буй тохиолдолд хувь хүний нууцыг задруулахгүй байхыг  
холбогдох хуулийн этгээдээс шаардах эрхтэй буюу хувь хүнийг тодорхойлох, таних,  
илрүүлэхүйц мэдээллүүд болох нэр, овог, үнэмлэхийн дугаар, хаяг, байршил,  
утасны дугаар болоод аж амьдрал, амьдралын хэвшлийн тухай мөн эд хөрөнгө  
 болоод нийгмийн гарал үүсэл зэрэг албан ёсны статистик, судалгаа шинжилгээний  
хүрээнд цуглуулагдсан мэдээллүүд нь хувь хүний эмзэг мэдээлэлд хамаарах бөгөөд  
албан ёсны статистик гаргахаас бусад зорилгоор хэрэглэгдэх ёсгүй юм. Дээр  
дурдсан болоод бусад хувийн мэдээлэлтэй холбогдох өгөгдөл, мэдээлэл нь  
нууцлал, хамгаалалт бүхий зориулалтын орчинд хадгалагдах бөгөөд албан  
хэрэгцээнд хэрэглэх тохиолдолд зохих албан тушаалтны зөвшөөрөлтэйгөөр  
хэрэглэнэ.

Хувиргасан өгөгдөл

Хувь хүнийг тодорхойлж болохуйц мэдээлэл агуулсан  
өгөгдөлд тухайн хувь хүнийг тодорхойлох өгөгдлийг  
зохиомлоор өөрчилснөөр хувь хүнийг таних,  
тодорхойлооос сэргийлэн хувиргасан өгөгдөл.

Түүхий өгөгдөл

(эс бөгөөс үндсэн өгөгдөл) Аливаа нэгэн үйлдэл болоод  
өөрчлөлт хийгдээгүй буюу боловсруулагдаагүй  
компьютерийн өгөгдөл

Бичлэг	Ном хэвлэл, бичиг баримт, газрын зураг, зураг хөрөг, гэрэл зураг, захидал, тараах материал, сонин сэтгүүл болон мэдээлэл хэвлэгдсэн хадгалагдсан бүхий л зүйлсийг түүнчлэн зураг дүрс, цахим болоод механик хэлбэрийн аль алинаар бичигдсэн хадгалагдсан аливаа зүйлс
Ашиглах, хэрэглэхэд тавигдах шаардлага	Нээлттэй болгон нийтэлсэн бүрдэл болон хэсэгчилсэн өгөгдөлтэй хамтаар нийтлэгдэх нээлттэй өгөгдөлд хандахад тавигдах нөхцөл шаардлага, зохицуулалтын талаарх мэдээлэл. Энэхүү мэдээлэлд хэрэглэгч буюу хувь хүн, аж ахуйн нэгжийн зүгээс хүлээх үүрэг хариуцлага, өгөгдлийг хэрэглэх зорилго, нөхцөл шаардлага болон өгөгдлийг нийтэлсэн байгууллагын эрх үүрэг зэргийн талаар дурдсан байна.

Нээлттэй өгөгдлийг хэрэглэх, ашиглахад тавигдах нөхцөл шаардлагад хэрэглэгчийн зүгээс “нээлттэй өгөгдэл, мэдээллийг арилжааны болоод арилжааны бус зорилгоор ашиглах, хэрэглэх зэргээс үл хамааран хуулбар хийх, тараан түгээх, хадгалах зэрэгт ямар нэгэн хориг саадгүй, үнэ төлбөргүйгээр хэрэглэнэ” гэдгийг зайлшгүй дурдсан байна. Төрийн нээлттэй өгөгдэл, мэдээллийг дээр дурдсан болоод ижил төстэй зорилгоор хэрэглэх тохиолдолд хэрэглэгч нь тухайн өгөгдэл, мэдээллийн байршил, анхдагч эх үүсвэр зэргийг заавал дурдсан байх шаардлагыг биелүүлнэ. Өгөгдэл мэдээллийн анхдагч эх үүсвэр буюу мэдээллийг цуглуулсан, нийтэлсэн, үүсгэсэн байгууллага, этгээд нь тэдгээрийн зүгээс нээлттэй болгон нийтэлсэн өгөгдэл, мэдээллийн хэрэглэгч, үйлчлүүлэгчид бусдын зүгээс учруулсан ямар нэгэн буруутай үйлдэлд хариуцлага хүлээхгүй бөгөөд өөрийн зүгээс нийтэлсэн хэсэгчилсэн болон бүрдэл өгөгдэл мэдээлэлд өөрчлөлт оруулах, эс бөгөөс буцаан татах зэрэг үйлдэл хийх эрхийг эдэлнэ. Эдгээр нөхцөл шаардлагууд нь нийтлэгдэх өгөгдэл, мэдээллийн хамтаар нийтлэгдэх мэдэгдэл хэсэгт заавал дурдагдсан байна.

Сайн дурын үндсэн  
дээр нийтлэх

Хувь хүн, аж ахуйн нэгж болоод олон нийтийн  
зүгээс хүсэлт гаргасан болоод шаардсан эсэхээс үл

хамааран Төрийн байгууллагууд нь өөрт буй төрийн  
мэдээллийг тогтсон хуваарийн дагуу сайн дурын  
үндсэн дээр олон нийтэд нээлттэй болгоно.

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл нь Монгол Улсын төрийн байгууллагуудын өгөгдлийг иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагууд болоод холбоодод ил тод, нээлттэй болгон хүргэхэд баримтлах чиглэлийг тодорхойлно.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолын дагуу Цахим засаг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийн хүрээнд төрийн үйлчилгээг хүртээлтэй, чирэгдэл багатай хүргэх, нээлттэй засаглал, иргэн төвтэй төрийн үйлчилгээг бий болгох улмаар төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар хийгдэж буй арга хэмжээний салшгүй хэсэг нь төрийн өгөгдөл, мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй болгох юм. Төрийн мэдээллийг нээлттэй болгосноор төрийн байгууллагын тогтоол шийдвэрийг нийтэд сурталчлах, таниулах, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах мөн төрийн өгөгдөл, мэдээллийг ашиглан шинэ үйлчилгээ, хэрэглээ бий болгох, төрийн үйлчилгээний уламжлалт хэлбэрээс цахим үйлчилгээнд шилжих шилжилтийн явцыг түргэсгэх зэрэг давууд бий болно.

## ХОЁР. УДИРТГАЛ

Төрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд төрийн байгууллагын өдөр тутмын болоод бусад хэрэгцээнд зориулан цуглуулагдсан, үүсгэгдсэн өгөгдөл, мэдээлэл нь үндэстний баялаг, бүтээгдэхүүнд тооцогдох бөгөөд олон нийтийн хэрэглээ, тэдгээрийн эрх ашигт нийцсэн аливаа хэрэгцээнд зориулагдана. Төрийн байгууллагын нууцлал, аюулгүй байдал мөн хувийн мэдээллийн нэгдмэл, хамгаалагдсан байдалд аюул учрахуйц болон хувийн болон нууцлал бүхий мэдээлэл алдагдах нөхцөл байдал үүсгэхүйц өгөгдөл, мэдээллээс бусад мэдээлэлд хандах, хэрэглэх, ашиглах нь олон нийтэд нээлттэй байна. Төрийн ил тод, нээлттэй байдлыг идэвхжүүлэх, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах, төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх болон иргэдийн “төрд итгэх” итгэлийг нэмэгдүүлэхэд төрийн өгөгдлийг нээлттэй болгох нь нэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлийг хэрэгжүүлснээр нээлттэй засаглалыг хөгжүүлэх засаглалын бурдэл хэсгүүдийг нэгтгэх, уялдаа холбоог сайжруулах, цахим засаглалыг хөгжүүлэхэд дэмжлэг болох юм.

Төрийн мэдээлэл, өгөгдлийг нээлттэй болгох нь мэдлэгт суурилсан нийгэм эдийн засгийн суурийг бий болгоход чухал ач холбогдолтой бөгөөд төрийн мэдэлд хаалттай буюу иргэдийн зүгээс хандалт хийх боломжгүй бурдэл өгөгдөл болон түүхий өгөгдлийг иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагад нээлттэй болгосноор иргэд болон аж ахуйн нэгж, шинийг санаачлагч, бүтээгч нарын идэвх чармайлтыг нэмэгдүүлэн төрийн өгөгдөл болон мэдээллийг хувь хүн, олон нийт болоод бүлэг этгээдэд зориулсан мэдээллийн хэрэгсэл түүнчлэн нээлттэй өгөгдөл суурилсан компьютер, ухаалаг утасны програм үүсгэх түүнчлэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, төр иргэний хамтын ажиллагааны үр дүнтэй шийдэл бий болгох зэрэг эерэг хандлагууд бий болох юм.

Монгол Улс нь төрийн өгөгдөл, мэдээллийг нээлттэй болгож эхлээгүй хэдий ч статистикийн болоод дүн шинжилгээний мэдээллүүдийг хариуцсан байгууллагуудын цахим хуудсаар сар, улирал, жил тутам нийтлэхээс гадна тогтсон хугацааны давталттайгаар хэвлэгддэг сэтгүүл, товхимлоор дамжуулан олон нийтэд хүргэсээр байна. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын хэрэгжилтийг хангах, нийгэм, эдийн засаг, хүний хөгжил түүнчлэн эдийн засгийг төгөлдөржүүлэх, олон талт орлогын эх үүсвэр бий болгох, хүрээлэн буй орчны

тогтвортой хөгжлийг сайжруулах зэрэгт нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлснээр нээлттэй засаглал, төр иргэний хамтын ажиллагаа сайжран улмаар иргэд аж ахуйн нэгжийн зүгээс төрд тавих хяналт нэмэгдэх бөгөөд Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд томоохон түлхэц болох болно. Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлийг хэрэгжүүлснээр Монгол улсын төрийн мэдээллийг нээлттэй болгоод зогсохгүй үндэстний хөгжлийн чиг хандлага, зорилго, зорилтыг нийтэд таниулах, сурталчлах, уриалан дуудах, төрийн үйлчилгээний нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлэх, мэдлэгт суурилсан нийгэм эдийн засгийг бий болгон хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр бий болгох юм.

## ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН ХЭРЭГЛЭЭ

Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017–2025, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, нээлттэй засаглал, иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх сайжруулахад нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлийг хэрэгжүүлснээр мэдэгдэхүйц ахиц гаргах болно. Монгол Улсын Засгийн газар нь нээлттэй өгөгдлийг бий болгох, хэрэгжүүлэх тал дээр үлгэрлэн бусад төрийн байгууллагуудыг манлайлан улмаар төрийн өгөгдлийг олон нийтэд ил тод, нээлттэй болгоход тавигдах нөхцөл шаардлагуудыг боловсруулан хэрэгжүүлж засгийн газрын шууд ба шууд бус харья төрийн байгууллагуудын зүгээс нээлттэй өгөгдлийн бодлогын хэрэгжүүлэлтийн биелэлтийг хянадаг, удирддаг байх шаардлагатай юм. Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлийн хэрэгжилтэд Засгийн газрын хэрэг эрхлэх газар болоод харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавин, удирдлагаар хангах, бодлогоор чиглүүлэх үүргийг хүлээнэ.

Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл нь хувийн өгөгдөл, хувь хүний болоод байгууллагын нууцын тухай хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж болон бусад холбогдох бичиг баримт, гэрээ хэлцлээр хориглосноос бусад бүхий л төрийн мэдээлэл, өгөгдлийг олон нийтэд ил тод болгох, цахим орчинд нийтлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл нь Монгол Улсын төрийн байгууллагуудад агуулагдаж буй түүнчлэн тэдгээрийн чиг үүргийн хүрээнд цугларсан болон үүсгэгдсэн, хадгалагдсан бүхий л өгөгдөл, мэдээлэлд хамаарна.

## ДӨРӨВ. БОДЛОГЫН ЧИГЛЭЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГУУД

Төрийн байгууллагууд нь нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлийн хэрэгжилтийн хүрээнд өөрт буй хувийн болоод байгууллагын нууцад үл хамаарахаас (хувь хүнтэй холбогдох, нууцын зэрэглэлтэй, аюулгүй байдал, худалдааны нууцлал, хамтын гэрээгээр хүлээсэн нууцлал хадгалах үүргээ биелүүлэх болон бусад хууль тогтоомжоор хориглосон) бусад өгөгдөл, мэдээллийг олон нийтэд ил болгох үүрэг хүлээнэ.

Монгол Улсын Их Хурал болоод Монгол Улсын Засгийн Газарт шууд болон шууд бусаар харьяалагдах бүхий л төрийн байгууллагууд төрийн өгөгдлийг нээлттэй болгохтой холбогдуулан дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ:

### 4.1. Нээлттэй өгөгдлийн удирдлага

Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллага бүр өөрт байгаа өгөгдөл, мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох ажиллагааг хариуцсан албан тушаалтныг (ахлах мэргэжилтэн, албаны дарга болон түүнээс дээш албан тушаалтан) томилон ажиллуулна. Тухайн албан тушаалтан нь дараах эрх үүрэгтэй байна:

- 1) Байгууллагын нээлттэй өгөгдлийн төлөвлөгөөг хянах, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлагаар хангах;
- 2) Нээлттэй өгөгдлийн каталогид мэдээлэл болон өгөгдлийн санд нэмэн оруулах хэсэгчилсэн болон бүрдэл өгөгдлийг хянах, үнэлэх, дүгнэх;
- 3) Нээлттэй болгохоор зэхэж буй бүрдэл өгөгдлүүдэд үнэлэлт дүгнэлт хийн тухайн бүрдэл өгөгдлийг нийтэд ил болгох эсэх шийдвэр гаргах;
- 4) Өгөгдөл болоод мэдээллийг тогтсон хуваарийн дагуу олон нийтэд нээлттэй болгох талаар арга хэмжээ авч ажиллах;
- 5) Нээлттэй өгөгдөлтэй холбоотой олон нийтийн зүгээс гаргасан асуулт, хүсэлт зэрэгт зохих журмын дагуу хариулт өгөх, хүсэлтийг шийдвэрлэх.

Төрийн байгууллага нь тус үүргийг биөчлэн хүлээсэн албан тушаалтан томилон ажиллуулаагүй тохиолдолд мэдээллийн технологийн хэлтсийн дарга, менежер эс бөгөөс харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн

төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон албан хаагч хавсралт 2 (Гүйцэтгэх үүрэг хүлээх хариуцлага)-д заасны дагуу дээрх үүргийг гүйцэтгэнэ.

#### 4.2. Нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах

Төрийн байгууллагууд нь өөрт буй өгөгдөл, мэдээллийг нээлттэй болгох, цахим орчинд нийтлэхтэй холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэн даруй гарган хэрэгжүүлнэ. Нээлттэй болгосон өгөгдлийн хамтаар цахим орчинд тавигдах мэдэгдэлд “Нээлттэй өгөгдлийг хэрэглэх, ашиглах нөхцөл шаардлага” болон өгөгдлийн зохистой хэрэглээний талаарх зөвлөмж болон нээлттэй өгөгдөл, мэдээллийг дахин хэрэглэх, түгээх, хадгалах зэрэгт ямарваа нэгэн төлбөр, тэдгээрийн хэрэглээнд тавигдах хориг саад байхгүй талаар заавал дурдсан байна.

Төрийн байгууллагууд нь нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө төрийн байгууллагын нээлттэй байдлыг сайжруулах тал дээр хийгдэж буй мөн хийхээр төлөвлөсөн арга хэмжээний талаар дурдахаас гадна төрийн зүгээс гаргаж буй шийдвэрт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлэх алхмуудыг дурдсан байна. Төлөвлөгөөнд олон нийтэд нээлттэй болгох бүрдэл өгөгдлийн бүтэц зориулалт, зорилго зэргийг тодорхой дурдахаас гадна бүрдэл өгөгдлийн нийтлэгдэх хугацааны давтамж зэргийг тусгасан байна.

Байгууллага бүр нээлттэй өгөгдлийн цахим хуудас үүсгэн тогтсон хуваарийн дагуу тохиргоог шалгах болон нэмэлт сайжруулалт зэргийг хийж байнгын ажиллагаатай байлгана. Байгууллагуудын үүсгэсэн нээлттэй өгөгдлийн цахим хуудсууд нь нээлттэй өгөгдлийн үндэсний порталд холбогдсон байна.

#### 4.3. Нээлттэй өгөгдлийг цахим орчинд нийтлэх

1) Байгууллагууд нь өөрт өгөгдлийг хүчин төгөлдөр үйлчилж буй хууль дүрэм, холбогдох тогтоомж, журам болон гэрээгээр хүлээсэн үүрэг зэргээр хориглосноос бусад тохиолдолд цахим орчинд нийтэлнэ. Нийтэлсэн өгөгдөл, мэдээлэлд эрэмбэлэх болон хайлт хийх боломжтой байна.

2) Нийтэлсэн өгөгдөл, мэдээлэлд аливаа нэг хувь хүнийг шууд болоод шууд бусаар тодорхойлох өгөгдөл, мэдээлэл байх ёсгүй. Хувь хүнийг шууд болон шууд бус хэлбэрээр буюу бусад өгөгдөл мэдээлэлтэй хавсарснаар тодорхойлж болохуйц өгөгдөл, мэдээлэлд тухайн өгөгдөл, мэдээлэл нийтлэгдэхээс өмнө өөрчлөлт оруулж хувь хүнийг таних, тодорхойлох бололцоогүй болгосон байна.

3) Олон нийтэд нээлттэй болгон нийтлэхээр зэхэж буй өгөгдөл, мэдээлэл нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, хувийн мэдээллийн нууцлал, үндэсний аюулгүй байдал, аюулгүй байдлын бодлого, худалдааны нууц, гэрээгээр хүлээсэн үүрэг зэрэгт заасан хоригуудын аль нэгийг зөрчөөгүй гэдгийг магадлан шалгаж тухайн өгөгдөл, мэдээллийг нийтлэх эсэх шийдвэр гаргахдаа байгууллагууд нь нээлттэй өгөгдөлд хийх үнэлгээний аргачлал боловсруулан тухайн аргачлалын дагуу үнэлгээ хийж дүгнэлт гаргасан байна.

4) Байгууллагууд өөрт буй бүрдэл өгөгдлийн үнэ цэнэ, хэмжээ, өгөгдлийн чанар, олон нийтийн эрэлт хэрэгцээ мөн үйл ажиллагааны зохицолдоо болон байгууллагын үүрэг зориулалт зэрэг хүчин зүйлс дээр дүн шинжилгээ хийж байгууллагын зүгээс нийтэлсэн өгөгдлийн нийтэд үзүүлэх үр өгөөжийг тооцох аргачлал боловсруулан үйл ажиллагаандaa мөрдлөг болгож хэвшүүлнэ.

5) Байгууллагууд нийтэд нээлттэй болгосон өгөгдөл, мэдээллийн талаар хэрэглэгчдийн зүгээс интернетийн орчинд өгөгдөл гаргах, нийтэлсэн өгөгдөл мэдээлэлд хайлт хийх боломжийг бий болгохоос гадна нийтэлсэн өгөгдлийн талаар товч ойлголт авахад дөхөм болгох үүднээс бүрдэл болон хэсэгчилсэн өгөгдөл, мэдээллийн метадата үүсгэнэ.

6) Байгууллагууд нь нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд үүсгэн бий болгосон цахим хуудсандаа тухайн байгууллагын зүгээс нийтэд нээлттэй болгосон аливаа нээлттэй өгөгдөл, мэдээлэл нь хэрэглэх, ашиглахад үнэ төлбөргүйгээс гадна хадгалах, цуглуулах, дахин дамжуулах зэрэгт ямарваа нэгэн хориг саадгүй хэмээн мэдэгдсэн мэдэгдлийг байршуулна. Тухайн цахим хуудсыг хэрэглэхэд тавих нөхцөл шаардлагад мөн энэ талаар дурдсан байвал зохилтой.

#### 4.4. Нээлттэй өгөгдлийн форматууд

1) Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлийн хүрээнд нийтэд нээлттэй болгосон бүхий л өгөгдөл, мэдээллүүд нь нээлттэй форматтай байна. Нээлттэй формат нь бие даасан платформ бүхий машинд боловсруулагдах боломжтой олон нийтэд нээлттэй мөн ашиглах, хэрэглэх болоод дахин хэрэглэх зэрэгт ямарваа нэгэн хориггүй байна.

2) Нийтэд нээлттэй болгосон бүрдэл болон хэсэгчилсэн өгөгдөл, мэдээлэл нь ямар нэгэн боловсруулалт хийгдээгүй мөн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж буй хэсгүүд болон мэдээллийн бүрэн бүтэн байдалтай холбогдох бүхий л салангид

хэсгүүдийг бүхэлд нь агуулсан байвал зохилтой түүнчлэн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, хувийн мэдээллийн нууцлал, мэдээллийн аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг хангасан байна. Нээлттэй өгөгдөл, мэдээлэлд хандалт хийх, хэрэглэх, хадгалах болон түгээхэд ямарваа нэгэн хориг үгүй болоод үнэ төлбөргүй байна.

3) Байгууллагууд нь өөрийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд үүсгэсэн, цуглуулсан, хадгалсан өгөгдлийг нээлттэй өгөгдлийн системд нийтэд ил болгон нийтлэхдээ хэрэглэгчийн зүгээс интернетийн орчинд хийгдэх үйлдлүүдийг хялбаршуулах зорилгоор бүрдэл өгөгдлийн каталогийг үүсгэн байршуулна. Нээлттэй өгөгдлийн каталог үүсгэх нь байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох үйлдлийг сайжруулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, мэдээллийн давхардлыг арилгахад чухал ач холбогдолтой.

#### 4.5. Олон нийтийн хандлагыг тандах

1) Байгууллагууд нь өөрт харгалзах нээлттэй өгөгдлийн цахим хуудсаараа дамжуулан цахим орчинд олон нийтийн хэлэлцүүлэг, форум хийх боломжийг бий болгосон байна. Тухайн цахим хэлэлцүүлэг, форумд иргэн аж ахуйн нэгжийн зүгээс санал сэтгэгдлээ илэрхийлэх бололцоог бий болгосон байна.

2) Нээлттэй өгөгдлийн цахим хуудас нь хэрэглэгчдийн зүгээс мэдээлэл хүссэн болон нээлттэй өгөгдөл, мэдээлэлтэй холбоотой аливаа өргөдөл, хүсэлтийг цахимаар гаргах боломжийг бүрдүүлсэн байна.

3) Байгууллагууд нь олон нийтийн зүгээс ирүүлсэн нээлттэй өгөгдөл, мэдээлэлтэй холбоотой санал, хүсэлтэд тогтсон хугацаанд хариу өгнө. Цахимаар болон бусад хэлбэрээр гаргасан хүсэлтэд хүсэлтийг хүлээн авсан өдрөөс эхлүүлэн нийт 15 өдрийн дотор багтаан хариу хүргүүлнэ. Хэрэглэгчийн хүсэлтийн дагуу нээлттэй болгон нийтлэх боломж бүхий өгөгдөл, мэдээллийг бэлдэх, нийтлэх зэрэг нь энэхүү хугацаанд орохгүй бөгөөд хүсэлт гаргагчийн хүссэн өгөгдөл, мэдээллийг нээлттэй болгох боломжтой эсэх болоод нээлттэй болгон нийтлэхэд зарцуулагдах хугацаа, нийтлэх арга хэлбэрийн талаарх мэдээллийг хүсэлт гаргасан хэрэглэгчид хүргүүлэх хариунд дурдсан байвал зохилтой. Байгууллагууд нь өөрт харгалзах нээлттэй өгөгдлийн цахим хуудсанд хэрэглэгчийн хүсэлтэд цахим орчноор дамжуулан хариулт өгөх горим үүсгэн ажиллуулна.

4) Хэрэв байгууллагуудын зүгээс хэрэглэгчийн хүссэн өгөгдөл, мэдээллийг нээлттэй өгөгдлийн үнэлгээ хийсний үндсэн дээр олон нийтэд нээлттэй болгон нийтлэх нь боломжгүй хэмээн шийдвэрлэсэн тохиолдолд 4.5 (в)-д дурдсан хугацаанд багтаан тухайн шийдвэрийн талаар хэрэглэгчид хариу мэдэгдэнэ.

5) Мэдээлэл хүссэн хүсэлтэд дурдсан өгөгдөл, мэдээлэлд байгууллагууд нээлттэй өгөгдлийн үнэлгээ хийн хэсэгчилсэн болон бүрдэл өгөгдөл, мэдээллийг нийтэд нээлттэй болгох эсэх талаар шийдвэр гаргана.

6) Байгууллагуудын зүгээс энэхүү баримт бичгийн 4.6-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр тодорхой хугацааны давтамжтайгаар нийтэд нээлттэй болгохоор шийдвэрлэснээс бусад өгөгдөл, мэдээллийг нээлттэй болгох өргөдөл, хүсэлтийг олон нийтээс гаргасан тохиолдолд тухайн хүсэлтэд дурдсан өгөгдөл, мэдээллийг нээлттэй болгохтой холбоотойгоор шаардагдах нэмэлт тоног төхөөрөмж, ажлын цар хүрээтэй уялдуулан тогтоосон төлбөрийг хүсэлт гаргасан хэрэглэгчээс нэхэмжилж болно. Байгууллагууд нь өгөгдөл, мэдээллийг хэрэглэгчийн хүсэлтэд үндэслэн нээлттэй болгон олгохтой холбоотойгоор үүсэж болох нэмэлт төлбөрийн талаар мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулсан байна.

#### 4.6. Тогтсон хуваарь, шийдлийн дагуу нийтлэх мэдээлэл

1) Төрийн байгууллагууд нь олон нийтийн хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээ болоод мэдээллийн үнэ цэнэ зэрэг дээр үндэслэн хууль тогтоомж, хувь хүний нууц, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээр хориглосноос бусад өгөгдөл, мэдээллийг төрөл зүйл, хэмжээнээс нь хамааруулан нийтэд нээлттэй болгох болон нийтлэх хугацааны давтамжийг тодорхойлно. Олон нийтэд нээлттэй болгохоор шийдвэрлэсэн өгөгдөл, мэдээлэлд тэдгээрийг нийтлэхээс өмнө нээлттэй өгөгдлийн үнэлгээ хийсэн байх шаардлагатай.

2) Байгууллагын зүгээс тогтсон хуваарийн дагуу олон нийтэд нээлттэй болгож буй өгөгдөл, мэдээлэлд хэрэглэгчийн зүгээс хандалт хийхэд ямар нэгэн хүндрэл, саадгүй байна түүнчлэн олон тооны хэрэглэгч нэгэн зэрэг хандахад хүндрэл учрахааргүй байхаас гадна хэрэглэгчийн зүгээс ямар нэгэн бүртгэл хийлгэхийг шаардах ёсгүй. Нээлттэй болгон нийтэлсэн өгөгдөл, мэдээллийн формат нь нийтлэг бөгөөд түгээмэл байна.

3) Тогтсон хуваарийн дагуу нээлттэй болгох өгөгдөл, мэдээллийг олон нийтэд нээлттэй болгон нийтлэхээс өмнө байгууллагын зүгээс нууцлал, аюулгүй

байдал, зохиогчийн эрх, үүрэг болоод мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болохуйц бусад хүчин зүйлсийг нээлттэй өгөгдөл үнэлгээ хийх аргачлал боловсруулан тухайн аргачлалын дагуу үнэлгээ хийж тодорхойлсон байна.

4) Байгууллагын зүгээс нээлттэй болгооор шийдвэрлэсэн өгөгдөл, мэдээлэлд хийгдсэн үнэлгээ, шинжилгээнд үндэслэн тухайн өгөгдөл, мэдээллийг нээлттэй болгохыг хориглосон шийдвэр гаргасан тохиолдолд дээрх шийдвэртэй холбоотой баримт, нотолгоог баримтжуулан зориулалтын орчинд хадгална.

5) Тогтсон хуваарийн дагуу нийтэд нээлттэй болгооор шийдвэрлэсэн өгөгдөл, мэдээллийг хэрэглэх, ашиглах, хадгалах, дахин түгээхэд үнэ төлбөргүй байх бөгөөд хэрэглэх, ашиглахад тавигдах нөхцөл шаардлагыг тэдгээр өгөгдөл, мэдээлэлд хавсаргасан мэдэгдэлд нийтэлнэ.

6) Тогтсон хуваарийн дагуу нийтэд нээлттэй болгооор шийдвэрлэсний дагуу нийтлэгдсэн өгөгдөл, мэдээлэлд хандах, хэрэглэх, хадгалах, дахин түгээх зэрэгт хувь хүн, аж ахуйн нэгж буюу аливаа хэрэглэгчийн зүгээс ямарваа нэгэн бүртгэл хийлгэх шаардлагагүй.

#### 4.7. Нэмэлт шаардлагууд

1) Харилцаа холбоо, мэдээллийн технологи хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тухайн бодлогын чиглэлд тодорхойлогдсон үйл ажиллагааны дараалал, заавар, зөвлөмжид шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг хийх бөгөөд төрийн байгууллагууд нь нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлд орсон өөрчлөлт, шинэчлэлт зэргийг тухай бүр өөрийн үйл ажиллагаандaa хэвшүүлэн мөрднө.

2) Нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэлээр тавигдсан нөхцөл шаардлагуудыг нээлттэй өгөгдлийн бодлогын чиглэлийг хэрэгжүүлэгч бүхий л байгууллагууд өөрийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэгт тооцон идэвх чармайлт гарган ажиллана.

#### 4.8. Хэрэгжүүлэх арга замууд болон хэрэгжилтийг хянан нягтлах

1) Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэхүү бодлогын чиглэлийн дагуу хийгдэж буй нээлттэй өгөгдлийн хөгжүүлэлт, биелэлтийн явц, хэрэгжилт зэрэгт хяналт тавин ажиллах бөгөөд нээлттэй өгөгдөлтэй холбоотой өргөдөл гомдол, санал хүсэлтийг

шийдвэрлэсэн байдал болоод санал хүсэлтэд хүргүүлсэн хариулт зэрэгт хяналт тавин үнэлэлт дүгнэлт өгнө.

2) Хэрэглэгчийн зүгээс ирүүлсэн өгөгдөл, мэдээлэл авахаар хүссэн хүсэлтэд байгууллагуудын зүгээс хариу олгохтой холбогдуулан холбогдох өгөгдөл мэдээлэлд хийгдэх үнэлгээ, шинжилгээ хийхдээ харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвлөмж болгосон аргачлал дээр үндэслэн хийх бөгөөд байгууллагууд нь өөрийн үйл ажиллагааны онцлог болоод хэрэглэгчийн хүсэлт мөн бусад үзүүлэлт зэрэгт хамааруулан нээлттэй өгөгдөл, мэдээлэлд үнэлгээ, шинжилгээ хийх аргачлал шинээр боловсруулж болно. Байгууллагууд нь нээлттэй өгөгдлийн бодлогын чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зүгээс гаргасан нээлттэй өгөгдлийн хэрэгжүүлэлтийн талаарх илтгэл, тайлан зэргийг хүссэн албан хүсэлтэд зохих ёсоор хариу хүргүүлэх үүрэг хүлээнэ.

3) Байгууллагууд нь өөрт буй өгөгдөл, мэдээллийг олон нийтэд нээлттэй болгон нийтэлснээр тухайн өгөгдөл мэдээллийг ашиглан шинэ хэрэглээ үүсгэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр бүтээлтэй санал, санаачилга бий болох улмаар олон нийтийн дунд төрийн үйл ажиллагааны талаар эерэг хандлага нэмэгдэх зэрэг давуу талуудыг ойлгон ухамсарласан байхаас гадна олон нийтийн хэрэгцээ, шаардлагад үйлчлэх, олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх талаар санаачилгатай ажиллана.

Нээлттэй өгөгдөл хамаарах өгөгдөл, мэдээлэл нь:

- Интернетээр хандалт хийх боломжтой;
- Машинаар боловсруулалт хийх боломж бүхий форматтай;
- Нээлттэй зөвшөөрөл бүхий дахин давтан хэрэглэх боломжтой (арилжааны зорилгоор хэрэглэх, дахин ашиглах);
- Үнэ төлбөргүй, хууль дүрмээр хориглогдоогүй байна.

Төрийн байгууллагууд нь төрийн өгөгдөл, мэдээллийг нээлттэй болгоход тавигдах нэгдсэн үндэсний байгууллагаас зөвлөмж болгосон дараах нөхцөл шаардлагуудыг биелүүлбэл зохилтой:

## 1. БҮРЭН БҮТЭН

Төрийн байгууллага нь анх цуглуулсан болоод үүсгэсэн зорилго, боловсруулсан шалтгаан зэрэгтээ уялдсан бүрэн бүтэн, нэгдмэл өгөгдөл, мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоно. Аливаа нэг хувь хүн болон этгээдийг тухайллан таних, тодорхойлохуйц мэдээлэл түүнчлэн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомж болон бусад тогтоол, шийдвэрээр хориглосон өгөгдөл мэдээллээс бусад бүрдэл өгөгдлийг нийтэд ил тод, нээлттэй болгон нийтэлнэ. Нээлттэй болгон нийтэлсэн өгөгдөл, мэдээллийн хамтаар тэдгээрт хамаарах метадатаг нийтлэх бөгөөд нээлттэй өгөгдлийн тухай мэдэгдэл мөн нийтлэгдсэн байна. Энэхүү мэдэгдэлд нээлттэй өгөгдлийн тухай мөн түүхий өгөгдлийг хэрхэн ашиглавал зохистой талаар тайлбар, тооцоолол хийх төсөөллийн талаар дурдсан байна. Нээлттэй өгөгдөл, мэдээлэл болоод тэдгээрийг дагалдан нийтлэгдэх тайлбар, тодорхойлолтод тухайн өгөгдлийг хэрхэн үр дүнтэй ашиглах, хэрэглэхтэй холбоотой зөвлөмжийг агуулсан байна.

## 2. АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ

Төрийн байгууллагын зүгээс нийтэд нээлттэй болгож буй өгөгдөл, мэдээлэл нь анхдагч эх үүсвэрээс цуглуулсан өгөгдөл, мэдээлэл байна. Тухайн өгөгдөл, мэдээлэл нь төрийн байгууллагын эрхлэх үйл ажиллагааны хүрээнд анхдагч эх үүсвэрээс цуглуулсан өгөгдөл байна. Цуглуулагдсан өгөгдөл, мэдээлэл нь тэдгээрийг цуглуулсан зорилгын хүрээнд боловсруулагдсан байхаас гадна дээрх өгөгдөл, мэдээллийг нийтэд нээлттэй болгосноор олон нийтийн зүгээс тухайн

мэдээллийн үнэ цэнэ, эх үүсвэр баталгаатай эсэх болоод зориулалтын дагуу цуглуулсан мөн хадгалсан эсэхийг магадлан тодруулах боломжийг агуулсан байна.

### 3. ЦАГ ХУГАЦААТАЙ

Төрийн байгууллагын зүгээс олон нийтэд нээлттэй болгож буй бүрдэл өгөгдөл нь тодорхой хугацааны давтамжтайгаар нийтлэгдэнэ. Байгууллагууд нь өөрийн зүгээс тухайн өгөгдөл, мэдээллийг нийтэд нээлттэй болгох тал дээр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоор хориглосноос бусад буюу тэдгээрийн чиг үүргийн хүрээнд цуглуулагдсан болон үүсгэгдсэн мэдээллийг тухай бүрт олон нийтэд нээлттэй болгох үүрэг хүлээнэ. Цаг хугацаанаас шалтгаалж өгөгдөл, мэдээллийн үнэ цэнэ нь буурах эс бөгөөс ихээхэн хэмжээний өөрчлөлт орох зэрэг шинж чанар бүхий өгөгдөл мэдээллийг нэн тэргүүнд нийтэлнэ. Нийтэд хэдийнээ ил болгон нийтэлсэн өгөгдөл, мэдээлэлд тухайн мэдээллийн утга, агуулга зэрэгт өөрчлөлт орсон даруйд нь мэдээллийн анхдагч эх үүсвэрээс авсан өгөгдөл, мэдээллийг ашиглан сэргээх, шинэчлэх үйлдлийг гүйцэтгэнэ.

### 4. БИЕЧЛЭН БОЛОН ЦАХИМААР ХАНДАХ БОЛОЛЦООТОЙ

Төрийн байгууллагын зүгээс нийтэд нээлттэй болгож буй бүрдэл өгөгдөл, мэдээлэлд хэрэглэгч өөрийн сонгосон хандалтын хэлбэр буюу цахим болоод бусад хэлбэрээр хандах боломжтой байна. Өгөгдөл, мэдээллийг цаасан болоод бусад биет хэлбэрээр хүсэх тохиолдолд тодорхой нэгэн хаяг, байршил дахь албан хаагчдад хандан биечлэн хүсэлтээ гаргах бололцоотой байна. Интернетийн орчинд цахим маягуудыг бүрдүүлэх замаар хүсэлт гаргах бололцоотой байна. Түүнчлэн өгөгдлийн санд хадгалагдаж буй нийт өгөгдөл, мэдээллийг хэрэглэгчид зориулсан интерфэйс ашиглан нийтэд нь хуулж авах боломж бий болгосон байх шаардлагатай бөгөөд энэ нь тодорхой нэгэн өгөгдөл, мэдээлэлд компьютерийн хэрэглээний програмын тусламжтайгаар илүү хялбар хандах боломжийг олгох юм.

### 5. МАШИНД УНШИГДАХ

Цахим өгөгдөл боловсруулах зориулалт бүхий машинуудад тохиромжтой байхуйц өгөгдлийн оролтуудыг сонгон хэрэглэнэ. Нээлттэй өгөгдлийн санд байх өгөгдөл, мэдээлэл нь машинд уншигдах форматтай байх бөгөөд тэдгээрт хавсаргасан мэдээлэлд өгөгдлийн форматын талаарх мөн хэрхэн хэрэглэх, ашиглах талаарх зааварчилга, мэдээллийг хавсаргасан байна.

## 6. ЯЛГАВАРГҮЙ ХАНДАХ

Өгөгдөл, мэдээлэлд хандахад тухайн өгөгдлийн санг агуулж буй домэйнд бүртгүүлэх, гишүүнчлэл үүсгэхийг тулгах ёсгүй. Төлбөртэй програм хангамж, өндөр өртөг бүхий системийн шинэчлэлт хийсний үр дүнд өгөгдөл, мэдээлэлд хандах бололцоог олгох зэрэг хэрэглэгчид хүндрэл үүсгэх аливаа үйлдэл хийхийг хориглоно. Хэн нэгнийг болоод хэрэглэж буй систем, техник, технологи зэргээр нь ялгаварлалгүй өгөгдөл, мэдээллийг өргөн хүрээнд олон нийтэд түгээн тараах зорилгоор хэрэглэгчийн зүгээс ямарваа нэгэн бүртгэл хийлгэхийг шаардах ёсгүй. Хэрэглэгч нь өөрийн хувийн өгөгдлийг оруулж өөрийгөө нотлох шаардлагагүйгээр түүнчлэн ямар нэгэн шалгуургүйгээр нээлттэй өгөгдлийн санд хандалт хийх бололцоогоор бүрэн хангагдсан байна.

## 7. ХЭРЭГЛЭЭНД НЭВТЭРСЭН СТАНДАРТУУДЫГ ХЭРЭГЛЭХ

Хэрэглээнд өргөн нэвтэрсэн ("нээлттэй") стандартын форматуудыг өгөгдөл, мэдээллийг хадгалж буй байгууллагууд хэрэглэнэ. Нэг буюу тодорхой нэгэн компани, аж ахуйн нэгжийн эзэмшдэг мөн тэдгээрийн үйл ажиллагаанд ашигладаг стандартын дагуу хийгдсэн форматтай өгөгдөл, мэдээлэл нь тухайн компанийн боловсруулсан, бүтээсэн програм хангамжийг ашиглаж өгөгдөл, мэдээлэлд хандахаас өөр аргагүй нөхцөл байдал буй болгох бөгөөд үр дүнд нь тухайн програмыг олон нийтийн зүгээс ашиглахад нэмэлт төлбөр төлөхөөс аргагүй нөхцөл үүсгэнэ. Тиймээс байгууллагууд нь өгөгдөл, мэдээлэлд хандалт хийж буй хэрэглэгчийн зүгээс гарч болох аливаа хүндрэл бэрхшээлийг нарийн тооцож өгөгдөл, мэдээллийн форматыг дурын буюу хэрэглэгчийн сонгосон програмд ямар нэгэн саадгүйгээр боловсруулагддаг байх форматтай байхаар сонгоно.

## 8. ЛИЦЕНЗ

"Үйлчилгээний нөхцөл шаардлага" –д өгөгдөл, мэдээллийн эх үүсвэр, сурвалж зэргийг зайлшгүй дурдах талаар заавал дурдана. Өгөгдөл, мэдээллийг олон нийтэд тараан түгээхэд тавигдах ямарваа нэгэн хориг нь нээлттэй өгөгдөл, мэдээлэлд хандахад учирч болох хүндрэл, бэрхшээлд тооцогдох бөгөөд олон нийтэд хамаарах өгөгдөл, мэдээллийг нээлттэй, ил тод, хориг, саадгүйгээр хүргэнэ.

## 9. ТОГТВОРТОЙ

Байгууллагын зүгээс олон нийтэд ил тод болгон нийтэлсэн өгөгдөл, мэдээлэл нь үнэн зөв бөгөөд байгууллагын цахим хуудсанд тогтвортой оршин байна. Тухайн өгөгдөл, мэдээлэлд архивд шилжүүлсэн эсэхээс үл хамааран цахимаар хандах

боловцоотой байна. Байгууллагууд нь цахим орчинд буй өгөгдөл, мэдээлэлд хэрэглэгчдэд ямар нэгэн анхааруулга болоод урьдчилан сануулсан мэдэгдэл хүргүүлэлгүйгээр тухайн өгөгдөл, мэдээлэлд шинэчлэлт, өөрчлөлт хийхээс гадна өөрийн нийтэлсэн өгөгдлийг буцаан татах эрхтэй байна. Нээлттэй өгөгдлийн хүрээнд нийтлэгдсэн өгөгдөл, мэдээлэл нь нэгэн хэвийн тогтвортой байх, цахимаар хандах бололцоотой байх түүнчлэн тодорхой хугацааны эцэст тухайн өгөгдөл, мэдээлэл нь архивд шилжэдэг байх улмаар архивд шилжүүлсэн эсэхээс үл хамааран тэдгээр мэдээлэлд цахимаар хандах бололцоотой байх зэрэг шаардлагуудыг биелүүлсэн байна.

## 10. ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ

Олон нийтэд зориулан ил тод, нээлттэй болгон нийтэлсэн өгөгдөл, мэдээлэлд хэрэглэгчийн зүгээс хандахад учрах томоохон саад бэрхшээлийн нэг нь өгөгдөл, мэдээлэлд хандалт хийхэд тавигдах төлбөр юм. Төрийн байгууллагууд нь олон нийтийн зүгээс нээлттэй өгөгдөлд хандах хандалтад дараах үндэслэлүүдэд тодорхой хэмжээний төлбөр төлөхийг хэрэглэгчээс шаардах магадлалтай бөгөөд эдгээрт: мэдээллийг үүсгэхэд зарцуулж буй зардлыг тооцон өртөг тогтоох (мэдээллийг бий болгоход зарцуулсан зардлыг тухайн мэдээллийг худалдан авах магадлал бүхий үйлчлүүлэгчдийн тоонд хуваасан дүнгээр); мэдээллийг олж цуглуулахад зарцуулсан зардлаа нөхөх зорилгоор хуудас нэг бүрд эс бөгөөс гаргасан хүсэлт бүрд харгалзах; хүсэлтийг гүйцэлдүүлэхэд шаардагдаж буй үйл ажиллагааны үнэ; биет хуулбарын төлбөр гэх мэт.

Төрийн мэдээлэл нь төрийн байгууллагын гүйцэтгэх ажлын чиг үүргийн хүрээнд цуглуулагдсан өгөгдөл, мэдээлэл бөгөөд тэдгээрт хандах хэрэглэгчийн хандалтыг төлбөртэй болгох нь тухайн өгөгдөл, мэдээллийг цуглуулсан болоод үүсгэсэн анхдагч зорилт биш юм. Төрийн өгөгдөл, мэдээлэлд хандах хандалтыг төлбөртэй болгох нь олон нийтийн оролцоо, тэдний зүгээс хийгдэх хандалтад тавигдах томоохон хориг, саадын нэг болох бөгөөд төрийн үйл ажиллагааны ил тод байдал болоод бизнесийн өсөлт, бууралт, татварын орлого, төсвийн зарцуулалт зэрэгтэй холбоотой өгөгдөл, мэдээллийг олон нийтэд хүргэхэд учрах саад бэрхшээл юм.

## Хавсралт 2. Гүйцэтгэх үүрэг болон хүлээх хариуцлага

Гүйцэтгэх үүрэг болон хүлээх хариуцлага (Бодлогын чиглэлийн 4 дүгээр хэсэгт тодорхойлогдсон нөхцөл шаардлага) нь бодлогын чиглэлээр тавигдах нөхцөл шаардлагыг дэлгэрэнгүй тодорхойлно.

1. Өгөгдлийн менежмент хийх үүрэг бүхий удирдах түвшний албан хаагч нь нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор:

- өөрийн харьяа байгууллагын өгөгдөл, мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохтой холбоотойгоор байгууллагын ил тод байдал, олон нийтийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, сайжруулах;
- бодлогын чиглэлийн хэрэгжилт, нөхцөл шаардлагыг биелүүлэх, хэрэгжүүлэхэд хяналт тавин ажиллах;
- тус чиглэлийн хавсралт 5 (Бодлогын чиглэлийн зорилго) –д дурдсан нээлттэй өгөгдлийн төлөвлөгөөг гаргах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;
- нээлттэй өгөгдлийн хэрэгжилтийн явцад учирч буй бэрхшээлийн талаар дээд шатны удирдлагад тогтсон хугацаанд мэдээлж байх түүнчлэн холбогдох илтгэлийг авах хүсэлт гаргасан тохиолдолд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болоод Харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөвлөлд илтгэлийг хүргүүлэх;
- бодлогын хэрэгжилттэй холбоотой санал гомдлыг шийдвэрлэх, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас тус чиглэлд оруулсан өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр өөрийн үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж хэвшүүлэх.

2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар:

- Төрийн байгууллагын бүтэц, зориулалт, чиг үүрэг өөрчлөгдөх зэрэгт нийцүүлэн “Нээлттэй өгөгдлийн” бодлогын чиглэлд өөрчлөлт, шинэчлэлт хийх;
- Нээлттэй өгөгдлийн порталд байх каталогийн ангилал, тэдгээрт нийтлэгдэх мэдээлэлтэй холбоотой зааварчилга, зөвлөмжийг төрийн байгууллагуудад хүргүүлэх;
- Нээлттэй өгөгдлийн бодлогын чиглэлийг хэрэгжүүлэхэд үр дүнтэй нь батлагдсан арга барилыг нэвтрүүлэх, үйл ажиллагаандаа авч хэвшүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

- Нээлттэй өгөгдлийн каталогид байрших мэдээллийн төрөл, хэлбэр зэргийн талаар зөвлөмжийг төрийн байгууллагуудад хүргүүлэх;
- Төрийн байгууллагуудын зүгээс тус бодлогын чиглэлийн хэрэгжилтийг хангахад шаардагдах арга хэмжээний дараалал хэрэгжүүлэх аргачлалыг үүсгэн төрийн байгууллагуудад хүргүүлэх, дэмжлэг үзүүлэх;
- тус бодлогын чиглэлийн хэрэгжилт, хэрэгжилтийн явцыг хянан чиглүүлэх

3. Төрийн байгууллагууд дахь хууль зүйн хэлтэс / хуулийн зөвлөх нар дараах:

- шийдвэр гаргагч нарыг хувийн мэдээллийн нууцлал, нэгдмэл байдал болон мэдээллийн аюулгүй байдал, зохиогчийн эрхтэй холбогдох зөвлөмжөөр хангах;
- шийдвэр гаргагч нарыг хууль, тогтоомж болоод гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагатай холбогдох зөвлөмжөөр хангах зэрэг арга хэмжээ авах үүрэг хүлээвэл зохилтой.

Хавсралт 3. 2013 онд Их 8 улсын Нээлттэй  
өгөгдлийн талаарх зөвлөмж бүлэгт дурдсан зайлшгүй ил  
тод болгох шаардлагатай нээлттэй өгөгдлийн категори

Их 8 улсын Нээлттэй өгөгдлийн зөвлөмж бүлэгт дараах хүснэгтэд байх өгөгдөл, мэдээллийг нэн тэргүүнд нээлттэй болгохыг зөвлөмж болгосон бөгөөд засаглалыг сайжруулах мөн иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад чухал хүчин зүйл хэмээн цохон тэмдэглэсэн юм.

<b>Өгөгдлийн категори</b>	<b>Бүлэг өгөгдлүүд</b>
Компанийн мэдээлэл	Компани аж ахуйн нэгжийн бүртгэлийн мэдээлэл
Гэмт хэргийн гаралт, шийтгэл	Гэмт хэргийн гаралтын статистик мэдээлэл, сэрэмжлүүлэг
Хүрээлэн буй орчны мэдээлэл	Одон орон судлал, цаг агаар, хөдөө аж ахуй, ой, нуур, загас болоод ан агуурын мэдээлэл
Боловсрол	Сургуулийн нэрс, сургуулийн статистик үзүүлэлт, тоогоор илэрхийлсэн бусад мэдээлэл
Эрчим хүч, хот суурин, орчны мэдээлэл	Хөрс, ус, агаарын бохирдолтын түвшин, эрчим хүчний хэрэглээ
Эдийн засаг, хөрөнгө оруулалт	Төсвийн зардал, төрийн байгууллагын бусадтай хийсэн гэрээ хэлцэл, сонгон шалгаруулалтын урилга, зарлахаар зэхэж буй сонгон шалгаруулалт, орон нутгийн төсөв, улсын төсөв (төлөвлөсөн болоод зарцуулсан)
Газар зүйн мэдээлэл	Газар зүйн байршлын тогтцын мэдээлэл, шуудангийн код, үндэсний газар зүйн зураг болоод орон нутгийн газар зүйн зураглал
Хүнсний эрүүл мэнд	Тусlamж, хүнсний аюулгүй байдал, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, газрын мэдээлэл
Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, ил тод байдал	Төрийн байгууллага, албан тушаалтын мэдээлэл, харилцах хаяг, утасны дугаар, сонгуулийн дүн, хууль, тогтоомж, албан тушаалын мэдээлэл

	(цалингийн цэс), зочин хүлээн авах болоод бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан зардал
Хүний эрүүл мэнд	Жороор олгосон эмийн өгөгдөл, жороор олголтын өгөгдөл
Шинжлэх ухааны судалгаа шинжилгээ	Генетикийн өгөгдөл, мэдээлэл, боловсролын судалгаа шинжилгээ, үйл явц, туршилтын үр дүн
Статистик	Үндэсний статистикийн мэдээлэл, Хүн амын тоо, дэд бүтцийн өгөгдлүүд, эд хөрөнгийн болон боловсрол, ур чадварын мэдээлэл
Халамжийн хөтөлбөрүүд, ажиллах хүчний мэдээлэл	Орон сууцны мэдээлэл, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн тэтгэмжийн мэдээлэл
Тээвэр, дэд бүтэц	Нийтийн тээврийн хуваарь, зогсоол, харилцаа холбооны сүлжээний тархалт, холболтын мэдээлэл

Хүснэгтэд дурдсан өгөгдлүүд нь иргэдэд нээлттэй болгох мэдээллийн ерөнхий категори бөгөөд төрийн байгууллагын зүгээс өөрийн үйл ажиллагааны чиг үүрэг хүрээнд тухайн категорид дурдагдаагүй өгөгдөл, мэдээллийг олон нийтэд нэн хэрэгцээтэй хэмээн тооцон мөн онц чухал, яаралтай нийтлэх хэрэгцээтэй хэмээн үзсэн тохиолдолд тодорхойлсон өгөгдөл, мэдээллийг нийтэд нээлттэй болгон нийтлэх нь байгууллагын эрх, үүргийн нэгээхэн хэсэг юм.

## 1. МАШИНД УНШИГДАХ ФОРМАТУУД

Компьютер болон адилтгах төхөөрөмжид уншигдах өгөгдөл, мэдээллүүд нь машинд уншигдах өгөгдөл, мэдээлэлд тооцогдоно. Бичиг баримт боловсруулах зориулалт бүхий Ворд програмын тусламжтайгаар үүсгэгдсэн файлууд нь машинд уншигдах өгөгдөл, мэдээлэлд зүй ёсоор тооцогдох бөгөөд Ворд програм болон ижил зориулалт бүхий бусад програмын тусламжтайгаар тэдгээр файлуудыг хөрвүүлэн хэрэглэгчийн дэлгэцэд харуулж буй нь энгийн нэг нотолгоо юм. Үүний нэгэн адилаар HTML нь цахим хуудсыг дэлгэцэд хэрхэн харуулахыг тодорхойлсон стандарт юм. Гэвч эдгээр хэрэглээ нь хүний оролцоо шаардах буюу төхөөрөмжийг хэрэглэж буй хэн нэгэнд зориулан өгөгдөл, мэдээллийг харуулах, таниулах зорилго агуулсан болно. Нээлттэй өгөгдлийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд нийтэд зориулан нийтэлсэн өгөгдөл, мэдээлэл нь дахин ашиглах, дахин боловсруулах, зориулалтыг нь өөрчлөх болоод хүний оролцоогүйгээр автомат горим бүхий компьютерийн програмын тусламжтайгаар боловсруулагдах боломжтой байх шаардлагатай юм.

## 2. НЭЭЛТТЭЙ БОЛОН ХААЛТТАЙ ФАЙЛЫН ФОРМАТУУД

Нийтлэгдсэн өгөгдлийн форматууд нь – хадгалагдсан өгөгдөл, мэдээллийн тоон суурь нь – “нээлттэй” эсвэл “хаалттай” форматын аль нэг байна. Нээлттэй форматын үзүүлэлтүүд нь түгээмэл байх програмд зориулсан мөн үнэ төлбөргүй түүнчлэн тэдгээр үзүүлэлтийг хэн бүхэн өөрийн програм хангамжид тааруулан ашиглах, дахин хэрэглэх зэрэгт ямар нэгэн оюуны өмчийн эрхтэй холбогдох хориг саадгүй байна.

Нээлттэй форматын давуу талуудын нэг нь програм хөгжүүлэгчдийн зүгээс гаргаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо, хэмжээ, ангилал зэргээс шалтгаалахгүйгээр үнэ төлбөргүй, хориг саадгүйгээр хэрэглэх боломж олгодогт байдаг бөгөөд мөн тэдгээрт агуулагдаж мэдээлэл, өгөгдлийг дахин хэрэглэх, ашиглах зэрэгт саадгүй байдаг байна.

Тухайлсан нэг програмд зориулсан улмаар тэдгээр програмд л хэрэглэгддэг файлын форматууд нь нийтэд төдийлөн хүртээмжтэй байдаггүй бөгөөд форматын лиценз эзэмшигч эс бөгөөс тухайн програмыг хөгжүүлсэн гуравдагч этгээдээс хамааралтай байдал үүсгэдэг сул талтай. Өөрөөр хэлбэл өгөгдөл, мэдээлэлд хандахын тулд өндөр үнэтэй програм хангамж худалдаж авах эс бөгөөс олж

эзэмшихэд хүндрэлтэй ховор програм хангамжийг хайх зэрэг хүндрэлүүдийг хэрэглэгчид үүсгэдэг байна. Эдгээр давуу болон сул талуудыг харгалzan үзэж төрийн мэдээллийг нээлттэй, ил тод болгон нийтлэх үйлдлийг гүйцэтгэхдээ төрийн байгууллагууд нь нийтлэгдэх өгөгдөл, мэдээллийн форматыг нээлттэй болоод машинд уншигдах боломжтой байхаар сонгоно:

- **Дан текст** – Энэ төрлийн формат бүхий баримт бичиг (.txt) нь компьютер суурь бүхий програм хангамжид уншигдахад маш хялбар байдаг хэдий ч зарим тохиолдолд бичиг баримтад шаардагдах метадатаг агуулдаггүй тул тухайн бичиг баримтууд нь үүсгэгдсэн хэлбэрээсээ өөр хэлбэрт оруулахад төдийлөн тохиромжтой бус байдаг байна. Түүнчлэн тус форматтай мэдээллийг нэг үйлдлийн системээс нөгөө үйлдлийн систем рүү шилжүүлэн унших үед хөрвүүлэлтийн болоод бусад төрлийн алдаа гарах тохиолдлууд гардаг юм.
- **Текст формат бүхий баримт** – Бичиг баримтын нийтлэг форматууд болох Word, ODF, OOXML, мөн PDF нь энэ төрлийн формат бүхий өгөгдөл, мэдээллийн тод жишээ юм. Энэ төрлийн формат нь цахим шуудангийн хаягийн жагсаалт гэх мэт ойр ойрхон өөрчлөлт орох шаардлагагүй өгөгдөл, мэдээлэлд тохиромжтой байдаг байна. Тус форматтай өгөгдөл, мэдээлэл нь өгөгдөл нэмэх оролт гаралтын тусгайлсан бүтэцгүй бөгөөд автоматаар өгөгдөл нэмэх хасах үйлдэлд тохиромжгүй байдаг юм.
- **Таслалаар салгагдсан файлууд (CSV)** – CSV файлууд нь хэрэглээнд туйлын тохиромжтой форматын нэгт зүй ёсоор тооцогдох бөгөөд өгөгдөл, мэдээлэл орох, гарах бүтэц бүхий энэхүү формат нь тодорхой бүтэц бүрэлдэхүүнтэй их хэмжээний өгөгдлийг шилжүүлэх зөвөрлөхөд тохиромжтой юм.
- **Хүснэгт дэх мэдээлэл** – Microsoft Excel зэрэг програмын тусламжтайгаар үүсгэсэн уг форматтай өгөгдөл мэдээлэл нь түгээмэл хэрэглэгддэг бөгөөд баганад буй өгөгдөл, мэдээллийг ангилах, тайлбарлах зэрэгт тохиромжтой юм. Зарим тохиолдолд хүснэгтэн өгөгдөл, мэдээлэлд байх макро болон томьёолол зэрэг нь хандалт хийхэд төвөг учруулдаг талтай.
- **HTML** – Ихэнх цахим хуудаснууд нь HTML формат бүхий өгөгдөл, мэдээллийг агуулсан байдаг. HTML форматтайгаар хүснэгт бүхий өгөгдөл байршуулах нь өгөгдлийг нэгэн зэрэг харуулах, ангилах, хайлт хийх зэрэгт нь

тохиромжтой түүнчлэн өгөгдлийг өөрчлөх зэрэгт хялбар байдаг байна. Yahoo цахим хуудсанд байрласан өөрийн бүтэц бүхий мэдээллээс өгөгдөл, мэдээллийг гарган авахад хэрэглэгдэх хэрэглүүр бий болгосон (<http://developer.yahoo.com/yql/>) хүссэн нэгэн хэрэглэж болох давуу талтай юм.

- **JSON** – JSON формат нь дурын програмчлалын хэлэнд уншигдах энгийн болоод хялбар форматуудын нэг юм. XML зэрэг форматтай харьцуулахад хэрэглэхэд харьцангуй хялбар бөгөөд компьютерийн тусламжтайгаар аливаа өгөгдөл, мэдээлэлд боловсруулалт хийхэд илүү дөхөмтэй байдаг байна.
- **XML** – XML нь өгөгдөл солилцоход хамгийн ихээр хэрэглэгддэг формат бөгөөд өгөгдөл, мэдээллийг үүсгэхэд буюу буй болгосон файлын бүтцийг ямар нэгэн байдлаар өөрчилдөггүй давуу талтай юм.
- **RDF** – W3C-ийн зөвлөмж болгосон энэхүү RDF формат нь хэсэг өгөгдлийг бусад эх үүсвэрээс цуглуулсан адилтгах өгөгдөл, мэдээлэлтэй жишихэд хэрэглэгддэг юм. RDF формат бүхий өгөгдөл нь XML болон JSON формат бүхий өгөгдөл URL ашиглан хандалт хийх боломжтой бөгөөд нээлттэй өгөгдлийн цахим хуудсанд байрлах шууд холболт тогтоох боломж олгодог юм. Нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тухайн формат нь голчлон хэрэглэгдэж буй хэдий ч хараахан нийтийг хамарсан хэрэглээнд нэвтэрч амжаагүй байгаа болно.
- **Сканердсан зураг** – TIFF болон JPEG-2000 зэрэг зурган дээрх дурс, тэмдэглэгээ болон бусад зүйлсийн талаарх тэмдэглэгээ хийх боломж бүхий форматуудыг эс тооцвол нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлэх хүрээнд хэрэглэх форматуудаас хамгийн тохиромжгүй формат юм.
- **Өмчлөгдсөн форматууд** – Тодорхой хүрээнд хэрэглэх, ашиглах зориулалт бүхий системүүдэд зориулан бүтээсэн форматууд нь тухайн систем болоод програмуудад хэрэглэгддэг сул талтай юм.

- Их 8 улсын нээлттэй өгөгдлийн бүлэг
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогын чиглэл 2017 - 2025
- Хувь хүний нууцын тухай хууль
- Төрийн нээлттэй өгөгдөл иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. 2013 оны НҮБ-ын ЭЗНБХ (Эдийн засаг нийгмийн бодлогын хороо), ТУХМХ (Төрийн удирдлага хөгжлийн менежментийн хороо),
- Нээлттэй өгөгдлийн гарын авлага, Нээлттэй мэдлэгийн сан
- Нээлттэй өгөгдлийн бодлого, санамж бичиг болон үйл ажиллагааны төлөвлөгөө. АНУ
- Цахим хуудасны нэгдсэн сан, нээлттэй өгөгдлийн лавлагаа